



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 13 өдөр

Дугаар 6/28

Хэрлэн сум

Шагнах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.5, 11.1.7, Засгийн газрын 1997 оны "Аймаг нийслэлийн Засаг даргын олгох шагналын тухай" 54 дүгээр тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын сувилагч нарын баярын өдрийг тохиолдуулан хүн амын эрүүл мэндийн сахин хамгаалах их үйлст хувь нэмрээ оруулж, коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын үед үр бүтээлтэй ажилласан Нэгдсэн эмнэлгийн Халдвартын тасгийн сувилагч Н.Байгалмаа, Биндэр сумын Эрүүл мэндийн төвийн сувилагч Ц.Ариунаа нарыг аймгийн Засаг даргын нэрэмжит "Жуух бичиг" болон мөнгөн шагналаар тус тус шагнасугай.


2. Шагналын зардлын задаргааг хавсралтаар баталсугай.

3. Аймгийн Засаг даргын "Жуух бичиг" хийлгэх болон мөнгөн шагналд зарцуулах 1,030,000 (нэг сая гучин мянга)-н төгрөгийг аймгийн Засаг даргын шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны
05 дугаар сарын 13 өдрийн
5/28 дугаар захирамжийн хавсралт

Шагналын зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Нэг бүрийн үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ
1.	Мөнгөн шагналын хэмжээ	500,000	2	1,000,000
2.	Жуух бичгийн хэвлэлийн зардал	15,000	2	30,000
3.	Нийт			1,030,000